



Глоб Интернэшнл  
ТББ

# "ХҮНИЙ ЭРХИЙН МЭДЭЭЛМЭЭР ДАМЖУУЛАН ИРГЭНИЙГ ЧАДАВХЖУУЛАХ НЬ" ТӨСЛИЙН ХҮРЭЭНД БЭЛТГЭВ



Их Британий  
ЭСЯ

Глоб Интернэшнл ТББ, Монголын ТББ-ын форум

## САНАЛ

### ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАГЧДЫГ ХАМГААЛАХ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН ҮГҮЙЛЭГДЭЖ БАЙНА

"Хүний эрхийн хамгаалагч" гэж хэн бэ? Тэднийг яагаад хамгаалах ёстой вэ? Тэд ямар эрхтэй вэ? Ямар үүрэг хүлээдэг вэ?

Хүний эрхийн хамгаалагч гэдэгт хүний эрхийн төлөө тэмцэх, хөхиүлэн дэмжих ажлыг ганцаараа эсвэл бусадтай хамтран хийж байгаа хувь хүн, байгууллага, эвсэл, холбоо бүгдийг хамруулан ойлгодог. Хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах үүрэг төрийн анхдагч үүрэг хэдий ч эрхийн төлөө тууштай тэмцдэг, эрх мэдлийн цөөнхийн дуу хоолой болж явдаг хүний эрхийн хамгаалагчдын оролцоогүйгээр хүний эрх бодитой хэрэгжих боломжгүй билээ. Тиймээс олон улсын түвшинд хүний эрхийн хамгаалагчдыг хамгаалах, эрхийг нь баталгаажуулах асуудлаар олон чухал санал санаачлага өрнөж байна. НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 1998 онд баталсан Хүний эрхийн хамгаалагчдын тунхаглал (Тунхаглал гэх)-ыг онцгойлон дурьдаж болно.

Яагаад хүний эрхийн хамгаалагчдыг хамгаалах ёстой вэ? Дайн тулаанд хүмүүс бамбай, зэвсэггүй орвол юу ч хийж чадалгүй байсаар алтан амиа алдахад хүрэх нь тодорхой. Үүний нэг адил аливаа шударга бус явдлын эсрэг, хүний эрхийг бодитой эдлүүлэхийн төлөө тэмцэгчид нь ямар нэг баталгаа, хамгаалалтгүй бол мөн л ялгаагүй байдалд орж таарна. Тиймээс хүний эрхийн хамгаалагчдын үйл ажиллагааны баталгаа, хамгаалалтыг үндэсний хууль тогтоомжоор баталгаажуулах шаардлагатай юм.

Хүний эрхийн хамгаалагчдын эрх гэж цоо шинэ эрхийн асуудлыг яриагүй, харин тэднийг үйл хэргээ явуулахад зайлшгүй шаардлагатай тэдгээр эрхийг тодотгосон хэрэг билээ. Аливаа ардчилсан улсын иргэд үндэсний хууль тогтоомж болон нэгдэн орсон олон улсын гэрээнд туссан хүний эрх, эрх чөлөөгөө хамгаалуулах, бодитой эдлэхийг шаардах эрхтэй. Үүний тулд бусадтай хамтран эсвэл ганцаараа, төрийн бус байгууллага, холбоо байгуулах замаар ажиллах боломжтой байх ёстой. Мөн тайван замаар жагсаж, цуглах, мэдээллийг эрх, хайх, олж авах, эзэмших, хүний эрхийн шинэ асуудлыг хөгжүүлж, хэлэлцэх, хүлээн зөвшөөрүүлэхийн тулд нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулах, төрийн байгууллагын үйл ажиллагааг шүүмжлэх, сайжруулах талаар зөвлөмж өгөх, хүний эрхийг бодитой эдлүүлэхэд учирч байгаа асуудалд олон нийтийн анхаарлыг хандуулах, хүний эрхийг зөрчиж байгаа хууль, бодлогын талаар гомдол гаргах, шийдвэрлүүлэх зэрэг өргөн цар хүрээтэй үйл ажиллагаа явуулах эрх нь баталгаажсан байх учиртай. Ийнхүү тэмцэж яваад эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн тохиолдолд хууль тогтоомжоор үр дүнтэй хамгаалуулах, эрхээ сэргээлгэх, хохирлоо шударгаар нөхөн төлүүлэх асуудал ч үүнд хамаарна. Гэвч үйл ажиллагааны баталгаа болсон зарим эрхүүд хуулиар баталгаажилгүй өнөөг хүрсэн. Тухайлбал, мэдээлэл олж авах, хохирлоо барагдуулах, гэрч/хохирогчийг хамгаалах, шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог баталгаажуулах эрх зүйн орчин байхгүй байсаар байна.

Хүний эрхийн хамгаалагчид ямар үүрэг хүлээдэг вэ? Тунхаглалд заасны дагуу хүний эрхийн хамгаалагчид нь хүний эрх, эрх чөлөө, ардчилал, түүний тогтолцоог хамгаалах, хөхиүлэн дэмжихэд хувь нэмрээ оруулах, бусдын эрх, эрх чөлөөг зөрчихгүй байх үүргийг хүлээхийн зэрэгцээ хүний эрхийн төлөө хүчирхийллийн бус, тайван замаар тэмцэх ёстой.

Хүний эрхийн төлөөх үйл ажиллагаа нь ихэнх тохиолдолд бүхэл бүтэн тогтолцоо, хүчирхэг эрх мэдэлтнүүдтэй хийх тэмцэл байдаг тул тэднийг үр дүнтэй хамгаалах, эрхийг нь баталгаажуулах эрх зүйн зохицуулалтыг нэн даруй бий болгох шаардлага өнөөдөр тулгамдаж байна.